



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 04 өдөр

Дугаар А/499

Хэрлэн сум

Шагналд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.3 Аймгийн Засаг даргын 2003 оны А/99 дүгээр захирамжаар батлагдсан аймгийн “Хүндэт тэмдэг” олгох журам, 2015 оны А/511 дүгээр захирамжаар батлагдсан “Хан Хэнтийн алдартан тэмдэг олгох журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ахмадын баярын 30 дахь, Монголын багш нарын 56 дахь удаагийн баярын өдрийг тохиолдуулан салбартаа тасралтгүй олон жил үр бүтээлтэй ажиллаж, аймаг орон нутгийнхаа хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж байгаа нэр бүхий хүмүүсийг Засаг даргын “Жуух бичиг”-ээр шагнахад 735,000 (долоон зуун гучин таван мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх шагналд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн шагнал урамшуулал, буцалтгүй тусламжийн зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д гүйцэтгэлийг зохион байгуулж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2022 оны 10 дүгээр сарын 24-ны дугаар захирамжийн хавсралт

Зардлын тооцоо

№	Нэр	Нэгжийн үнэ	Тоо хэмжээ	Мөнгөн дүн
1	Жуух бичиг хийлгэх зардал	14.000	50ш	700.000
2	Үнэмлэх	350	100ш	35.000
	Нийт дүн			735.000